



ХЭНТИЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС



**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ
БОЛОН ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН
ГУРВАЛСАН ГЭРЭЭНИЙ ҮР ДҮНГИЙН БИЕЛЭЛТ**

ЧИНГИС ХОТ

2016 ОН

**ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ БОЛОН
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН ГУРВАЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Гэрээний агуулга, зорилт

“Хэнтий аймгийн Статистикийн хэлтсийн 2016 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө ” нь энэхүү гэрээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүнд төсвийн шууд захирагчаас хэрэгжүүлэх хөтөлбөр, нийт болон тусгай ажил үйлчилгээнүүд, манлайллын зорилтууд, тэдгээрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт(тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн)-үүд болон бусад эрх үүргийг тусгав. Энэхүү гэрээний зорилго нь үйл ажиллагаагаа оновчтой төлөвлөж хэрэгжүүлэх, ажлын байрны шаардлагад нийцүүлэн мэдлэг чадвараа дээшлүүлэх, төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, сонирхлын зөрчилгүй ажиллах, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж , төсвийн болон эд хөрөнгийг зохистой ашиглах, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх зэрэг манлайллын зорилтуудыг хангах талаар төсвийн шууд захирагчийн тухайн жилд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.Талуудын хүлээх үүрэг

Төсвийн шууд захирагчийн хүлээх үүрэг				
№	Үүрэг	Биелэлт	хувь	оноо
1.1	Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө ”-нд тусгагдсан нийт 23 ажил үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлнэ.	Энэхүү гэрээний хавсралт болох “Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө”-нд тусгагдсан нийт 23 ажил үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлж ажиллаа. Үндэсний Статистикийн Хорооны даргын мэдээ тайлангийн график батлах тухай 2015 оны 12-р сарын 30-ны өдрийн А/159 тоот тушаалаар баталсан албан ёсны статистикийн 54 мэдээ тайлан гаргахаас аймгийн хэмжээнд гаргах 46 мэдээ тайлан, захиргааны 18 төрлийн мэдээ тайлан, 8 судалгааг 6170 мэдээлэгчдээс давхардсан тоогоор 8572 удаа авч шалгаж боловсруулан 274 удаа телехолболтоор холбохоос хоцрогдолгүй 274 удаа графикт хугацаанд нь бүрэн дамжууллаа. /Дэлгэрэнгүйг тайланд тусгав/		

<p>1.2</p>	<p>Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон (2.24, 2.25, 2.26) тусгай 3 ажил үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлнэ.</p>	<p>Энэхүү гэрээний хавсралт болох "Байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө"-нд тусгагдсан арга хэмжээнээс төсвийн ерөнхийлөн захирагчийн тусгайлан сонгосон (2.24, 2.25, 2.26) тусгай 3 ажил үйлчилгээг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа, хүрэх үр дүн) бүрээр ханган хэрэгжүүлсэн.</p> <p>2.24. Үндэсний Статистикийн Хорооны даргын мэдээ тайлангийн график батлах тухай 2015 оны 12-р сарын 30-ны өдрийн А/159 тоот тушаалаар баталсан албан ёсны статистикийн 54 мэдээ тайлан гаргахаас аймгийн хэмжээнд гаргах 46 мэдээ тайлан, захиргааны 18 төрлийн мэдээ тайлан, 8 судалгааг 6170 мэдээлэгчдээс давхардсан тоогоор 8572 удаа авч шалгаж боловсруулан 274 удаа телехолболтоор холбохоос хоцрогдолгүй 274 удаа графикт хугацаанд нь бүрэн дамжууллаа.</p> <p>2.25. ҮСХ-ноос шаардсан графикт тусгаагүй мэдээ тайлан судалгааг цаг тухайд нь хугацаа хоцроолгүй шаардлагын түвшинд хийж мэйлээр, файл болон цаас хэлбэрээр бэлтгэж нийт 25 удаа ҮСХ-нд хүргүүлж ажиллалаа.</p> <p>2016 онд 8 төрлийн эдийн засгийн түүвэр судалгаа явагдсан. өрхөд суурилсан түүвэр судалгаанд нийт 3403 өрх, 153 хүн, 57 ААН сонгогдсон байна. Үүнээс: Хагас жилийн мал тооллогын түүвэр судалгаанд – 1532 өрх, ӨНЭЗСудалгаанд -624 өрх, 2016 онд "Ажиллах хүчний судалгаа"-ны нэмэлт IX бүлэг болж "Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгаа" " Ногоон ажлын байрны судалгаа" –нууд давхар явагдаж байна.</p> <p>Үүнд нийт -432 өрх, 32 хүн, Ардчилсан засаглал судалгаанд -102 хүн, Аж ахуйн нэгж, байгууллагын түүвэр судалгаанд Хөрөнгө оруулалтын түүвэр судалгаа орж байгаа бөгөөд уг судалгаанд нийт 6 аж ахуйн нэгж сонгогдсон байна.</p> <p>ААНБ-ын тооллогын ажлыг аймгийн хэмжээнд дөрөвдүгээр сарын 05-ны өдрөөс албан ёсоор эхлүүлсэн. Аймгийн төвийн Хэрлэн суманд уламжлалт аргаар тооллого явуулах гурван гэрээт ажилтан томилон ажиллуулсан. Аймгийн хэмжээнд 18 сумын нийт 1438 аж ахуйн нэгж байгууллага тооллогод хамрагдахаас 3 нь татан буугдсан, 3-ийн эзэн нь нас барсан, 20 нь хаяг тодорхойгүйгээс олдоогүй, 4 аж ахуйн нэгж давхардаж ирсэн, 1 байгууллага нууцын зэрэглэлтэй, 14 нь бусад шалтгааны улмаас</p>		
------------	---	--	--	--

нийт 45 аж ахуйн нэгж тоологод хамрагдах боломжгүй байв. Бусад хамрагдвал зохих аж ахуйн нэгжийг 100 хувь хамрууллаа. Уламжлалт аргаар тоологдсон 422 аж ахуйн нэгжийн бүртгэлийг кодлон, мэдээллийн санд шивж, баталгаажуулсан. Тоологод хамрагдаагүй аж ахуйн нэгжүүдийн шалтгааныг тодруулан холбогдох тайлбарыг УБСЕГ-т хүргүүлсэн

НАХ, СХТ-н судалгааг аймгийн хэмжээнд зохион явуулж нийт 51 ААН түүврээр сонгогдож ирсэн. НАХ, СХТ-н судалгааг салбар салбараар нь ахлах мэргэжилтэн А.Наранчимэг 8, мэргэжилтэн Б.Онончимэг 1, Н.Дагвадорж 23, гэрээт мэргэжилтэн Д.Мандхнаран 19 ААН-ийг хуваан авч уг судалгааг УБСЕГ-аас баталсан үзэл баримтлал, чиглэл, маягт зааврын дагуу мэдээллийг цуглуулан авав. Ахлах мэргэжилтэн А.Наранчимэг шалгагчаар ажиллаж маягт бүрийг шалган ҮСХ-д хүргүүлээд байна. Энэ судалгаанд 10 сумын 51 ААН хамрагдсан байна.

МАА-н орлого, зардлын судалгаа, Газар тариалангийн орлого, зардлын судалгаа явагдав. МАА-н орлого, зардлын судалгаанд 450 өрх, Газар тариалангийн орлого, зардлын судалгаанд 135 өрх сонгогдоод судалгааг авч дуусган ҮСХ-д дамжуулав.

Бичил уурхай эрхлэгчдийн судалгаанд 5 сумын 121 иргэн хамрагдав. бүрийг хянан үзэж газрын зургийн хамт ҮСХ-д хүргүүлээ. Улаанбурхан, гуд өвчний эсрэг дархлал тогтоцын судалгаанд Хэнтий аймгийн Баянмөнх, рээт сумын 94 өрх сонгогдон хамрагдав.

90-дээш настай -70 иргэн, 60-с дээш настай 4718 иргэний судалгааг гаргаж УБСЕГ, Аймгийн ИТХ, АЗДТГ, Чөлөөт ахмадын холбоо зэрэг байгууллагуудад, Сонгуулын насны хүн ам болон нийт хүн амын судалгааг сумдаар, багаар нь аймгийн ИТХ-д тус тус гаргаж өглөө.

0-18 насны хүүхдийн судалгааг насаар, сумаар нь гаргаж ДЗОУБ болон Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, Халамж үйлчилгээний хэлтэст өглөө. Хүн амын тоо болон 0-6 насны хүүхэд, нийт хүн амыг эрэгтэй, эмэгтэйгээр нь АЗДТГ болон сумдын өрхийн эмнэлэгүүдэд багаар нь гаргаж өгөв.

2.26. 60-с дээш настай – 4718 иргэдийн судалгааг гаргаж Аймгийн ИТХ, АЗДТГ-т гаргаж өглөө.

Хэнтий аймгийн хүн ам, өрх, нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтийг аймгийн ЗДТГ, нийгмийн даатгалын хэлтэст гаргаж өгсөн. Хүн ам, өрхийн судалгааг шаардлагатай газруудад 30 удаа гаргаж өгөв.


Аймгийн нийгэм эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн судалгааг сүүлийн 5 жилийн байдлаар, хүн амын шилжилт хөдөлгөөнийг сүүлийн 10 жилээр аймгийн засаг дарга болон агентлагуудад гаргаж өглөө.

Нийгмийн бодлогын хэлтэст Хэнтий аймгийн нийт эмэгтэйчүүдийн судалгаа нас насаар нь гаргаж өгөв.

Мянгат малчдын судалгааг АЗДТГ болон шаардлагатай газруудад 5 удаа гаргаж өгсөн.

Малын тоог урдчилсан байдлаар АЗДТГ-т гаргаж өгөв.

Махны жижиглэн болон бөөний үнийн судалгааг Хууль зүйн хэлтэст гаргаж өгсөн.



"Хэнтий мэдээ" сонинд статистик мэдээллийн булан нээж 7 хоног бүр тоо мэдээлэл өгөн ажиллаж байна. Мэдээг хавсаргаж оруулав.

/Дэлгэрэнгүйг тайланд тусгав/

1.3	Төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны манлайллын зорилтын хүрээнд дор дурьдсан арга хэмжээг хэрэгжүүлнэ.		
	Манлайллын зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	
1.3.1	Төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын	Хэнтий аймгийн ЗДТГазрын Дотоод Хяналт үнэлгээний шалгалт оруулж хэлтсийн бүх бичиг баримтанд хяналт үнэлгээ хийлгэж хангалттай гэсэн үнэлгээ авлаа.	

	<p>зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар:</p> <p>Зорилт -1: Статистикийн тухай хууль, Авилгын эсрэг хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.</p> <p>Зорилт -2: Төрийн захиргааны албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлнэ.</p>	<p>АЗДТГ-аас боловсруулсан сумдын засаг даргын бүтээгдэхүүн нийлүүлэлт үр дүнгийн гэрээг дүгнэх журманд хавсралт болгон 3 ерөнхий үзүүлэлт орууллаа.</p> <p>Статистикийн албаны хүний нөөцийн нэгдсэн системд хэлтсийн дарга 1, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 3, гэрээт мэргэжилтэн 1, түүвэр судалгааны ажилтан 3, жолооч 1, нийт 10 хүний анкетыг шивж оруулсан.</p> <p>Хэлтсийн ажилтнуудын 2016 оны үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээг дүгнэж мэргэжилтэн А.Наранчимэг, Г.Сэдэдмаа, Ц.Батхишиг нар “А” үнэлгээ, гэрээт ажилтан Б.Онончимэг, Д.Мандахнаран нар хангалттай гэсэн үнэлгээ авлаа.</p> <p>“Архигүй Хэнтийчүүд” хөтөлбөрийн хаалтын ажиллагааны хүрээнд “Өөдрөг амьдралд тэмүүлсэн он жилүүд” нэгдсэн арга хэмжээнүүдэд хэлтсийн хамт олон бүрэн оролцлоо.</p> <p>Аймгийн ИТХ болон Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан бүх албан байгууллага, аж ахуйн нэгжүүд хамрагдсан “Авто машингүй өдөр, бүх нийтийн алхалт” өдөрлөгт манай хэлтсийн хамт олон 100 хувь хамрагдан идэвхтэй оролцлоо.</p> <p>Аймгийн Засаг даргын захирамжийн дагуу “Эрүүл чийрэг Хэнтийчүүд” хөтөлбөрийн хүрээнд “Эрүүл чийрэг бие бялдар” өглөөний дасгалд хамт олноороо идэвхтэй оролцож байна.</p>		
1.3.2	<p>Байгууллагын ил тод байдлыг хангах талаар:</p> <p>Зорилт -1: Хэнтий аймгийн Статистикийн хэлтсийн цахим хуудасны хэрэглэгчийн хүрээг нэмэгдүүлэх ажлыг зохион</p>	<p>Хэвлэлийн бага хурлыг сар бүрийн 15-наас 20-ны хооронд тогтмол хийж хэвшлээ. Үүнд аймгийн “Хэнтий”, “Өндөрхаан” телевизүүд, Хэнтийн мэдээ сонинг тогтмол оролцуулж байна. Хэвлэлийн бага хурлаар сар бүрийн гаргадаг танилцуулга, цаг үеийн ажлын талаар мэргэжилтнүүд ээлжлэн оролцож нийт 12 удаа мэдээлэл хийлээ.</p> <p>ӨНЭЗС болон АХС-ны шторкыг “Хэнтий”, “Өндөрхаан” телевизүүдэд өгч 10 хоног өдөрт 10 удаагийн давталттайгаар 100 удаа эфирээр, мал тооллого, ААНБТ-ын шторкыг “Өндөрхаан”, “Хэнтий” телевизээр болон facebook хуудсаар өдөрт 10 удаагийн давталттайгаар сард 15 хоног буюу давхардсан тоогоор 1500 удаа эфирээр цацууллаа.</p> <p>Энэ онд "Хэнтийн мэдээ" сонины эрхлэгч Д.Одонтунгалаг,</p>		

	<p>байгуулж, үйл ажиллагааг сурталчилах</p> <p>Зорилт -2: Хүний нөөцийн ил тод байдлыг хангах</p> <p>Зорилт -3: Орон нутагт Статистикийн үйл ажиллагааг гардан зохион байгуулж байгаа ажилтан нарт харилцах үйл ажиллагааг өргөжүүлэх</p>	<p>Статистикийн хэлтсийн дарга Д.Болдбаатар нар 2016 онд хамтран ажиллах гэрээ байгуулж, 7 хоног тутам гардаг тус сонинд статистик мэдээллийн булан тогтмол ажиллаж, иргэд аймаг орон нутгийн талаарх төрөл бүрийн тоо баримт мэдээлэлтэй танилцаж ирлээ.</p> <p>Интернэт хэрэглэдэг хэрэглэгчдэд статистикийн мэдээллийн нэгдсэн сан www.1212.mn сайтаар сар бүр орж мэдээлэл авч байх талаар зөвлөмж өгч ажиллалаа. Интернэтгүй хэрэглэгчдэд Devinfo сангийн хэрэглэгээг сурталчилах зорилгоор monsis 1212 cd 20 ширхэгийг тархааж, аймгийн ЗДТГ-ын үүдэнд байршуулж байсан цахим самбарыг Эвт худалдааны төвд байрлах Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд шилжүүлэн байршуулж мэдээллийг тогтмол шинэчилж иргэдийг мэдээллээр хангаж ажиллалаа.</p> <p>Хэлтсийн facebook хуудсаар дамжуулан хэлтсийн хийж хэрэгжүүлсэн ажлаа тухай бүрт нь байршуулан сурталчлан ажиллаж байна.</p> <p>Статистикийн тухай хууль болон салбарын үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглан статистикийн хэлтсийн үүсэл хөгжил, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээний талаар “Хэнтийн мэдээ” сонинд тогтмол булан нээлгэн сар бүр 12 удаа мэдээлэл өгч хэлтсээ сурталчиллаа. Мөн дугаар бүрт үнийн мэдээллийг өгч нийтлүүлэв.</p> <p>Хууль болон салбарын үйл ажиллагааг сурталчилах зорилгоор орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон лекц хэлбэрээр 18 сум 4 тосгоныг оролцуулан 70 аж ахуйн нэгж, 9.0 мянган хүнд сургалт сурталчилгааг хийсэн байна.</p> <p>- ААНБТ-ын ажлын явцад Өндөрхаан, Хэнтий телевизүүдээр 4-р сард өдөрт 10 удаагийн давталттайгаар 15 хоног буюу давхардсан тоогоор 1500 удаа эфирээр тооллогын шторкыг цацууллаа. Өндөрхаан, Хэнтий телевизэд Зудаа тооллогын талаар мэдээлэл өгч УБСГ-ын дарга Б.Эрдэнэнамжилмаа, хэлтсийн дарга Д.Болдбаатар, ахлах мэргэжилтэн А.Наранчимэг нар ярилцлага өгөв. “Хэнтийн мэдээ” сонинд 2 удаа тооллогын талаар мэдээлэл бэлтгэж хэвлүүлэв.</p> <p>Байгууллагынхаа мэргэжилтэн, тоологч нарын бичиг баримтад үзлэг хийж, зөрчлийг арилгуулан бүрдүүлэв. Хэлтсийн мэргэжилтэн, гэрээт ажилтан нартай үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилласан</p>		
--	---	---	--	--

		<p>бөгөөд гэрээний биелэлтийг хагас бүтэн жилээр дүгнэж ажиллаа.</p> <p>Хэлтсийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн мэргэжилтнүүдийн жилийн бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөө, сар, улирал, 7 хоногийн төлөвлөгөөг батлан, гүйцэтгэлийг тухай бүр гаргуулан ажиллалаа. 2016 онд статистикийн хэлтсийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж холбогдох гэрээт ажилтан, тоологч, жолооч нарыг ҮСХ-той журмын дагуу зөвшилцөн томилж ажиллалаа.</p>		
1.3.3	<p>Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах талаар :</p> <p>Зорилт -1: Санхүүгийн талаар хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх</p> <p>Зорилт -2: Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудит, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг ил тод мэдээлэх</p>	<p>- Манай хэлтэс энэ жил 69 сая 810 мянган төгрөгийн үндсэн төсөвтэй ажиллалаа. Тухайн төсвийг гүйцэтгэлээр нь гаргахад ажилчдын цалинд 57903.1 мянган төгрөг, Нийгмийн даатгалын шимтгэлд 6370.3, Бараа үйлчилгээний зардалд 1403.3 мянган төгрөгийг зарцуулаад байна.</p> <p>- Нэмэлт санхүүжилтийн данс буюу судалгааны зардлыг нэг бүрчлэн гүйцэтгэлээр нь гаргахад ӨНЭЗС, АХС-ны зардалд 44710.3 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын зардалд 13936.1 мянган төгрөг, жилийн эцсийн мал тооллогонд 4600.0 мянган төгрөг, бусад төрлийн судалгаа болон үнийн мэдээнд 6722.4 мянган төгрөгийг зарцуулаад байна.</p> <p>- Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг 10 сараас эхлэн хийж гүйцэтгэв. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг бичиж ҮСХ-нд явууллаа.</p> <p>2015 оны санхүүгийн баримтыг аудитын газрын шалгалтанд оруулж зөрчилгүй гэсэн дүгнэлт авсан.</p> <p>Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны тоологч нар судалгааг хэрхэн зохион байгуулж байгаа байдалд үнэлэлт дүгнэлт өгөх, судалгаанд хамрагдсан өрхүүдэд очиж судалгааны дэвтрийн хөтлөлтийн байдалтай танилцаж, өрхөд олгож буй урамшууллын мөнгө өрхөд олгогдсон эсэхийг баримттай нь тулган шалгах ажлыг сар бүр судалгаанд хамрагдсан бүх суманд хийлээ. ӨНЭЗСудалгаанд хамрагдсан 18 сумын 48 багийн 642 өрхийн 72 өрхөд, АХСудалгаанд хамрагдсан 18 сумын 36 багийн 432 өрхийн 56 өрхөд,</p> <p>Хэлтсээрээ бие дааж хийсэн шалгалт: Аж ахуйн нэгжид- 22, ӨНЭЗС, АХС, судалгааны мониторингоор нийт 128 өрхөд, мал тооллогын хяналт 560</p>		

		өрхөд тус тус хийсэн байна. Аймгийн бусад байгууллагатай хамтарсан шалгалт 20 -ыг хийлээ.		
1.3.4	<p>Байгууллагын эд хөрөнгийг зохистой ашиглах талаар:</p> <p>Зорилт -1: Хэлтсийн биет хөрөнгийн нөөцийг зохистой ашиглах</p> <p>Зорилт -2: Үндсэн хөрөнгийн ашиглалтын талаар хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулахгүй байх</p> <p>Зорилт -3: Хэлтэст нэн шаардлагатай эд хөрөнгийг ҮСХ болон орон нутгийн төсөвт тусгуулж олж авах</p>	<p>1. Эд хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа хагас , бүтнээр тоолон бүртгэж шаардлагатай хөрөнгийн жагсаалтыг Аймаг, ҮСХ-нд гаргаж өгсөн. Хэлтсийн 2 машин хэвийн ямар нэгэн эвдрэл гэмтэлгүй ажиллаж байна. Ажилтнуудад эд хөрөнгийн карт хөтөлж өөрчлөлтийг тухай бүрд нь хийж хэвшлээ.</p> <p>2. Аймгийн ЗДТГ-ын үүдэнд байршуулж байсан цахим самбарыг Эвт худалдааны төвд байрлах Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд шилжүүлэн байршуулж мэдээллийг тогтмол шинэчилж иргэдийг мэдээллээр хангаж ажиллалаа.</p> <p>ҮСХ-оос Видео хурал зарласан тухай бүрд техник хэрэгслэлийг бэлэн байдалд бэлтгэн оролцож, мэдээлэл хүлээн авч байлаа. Хэлтсийн 3 өрөөг өөрсдийн нөөц бололцоогоор тохижуулж цэцэгжүүлж ажиллах нөхцлийг сайжрууллаа.</p> <p>3. ҮСХ-ноос 1 ш үзүүлэлт сайтай компьютерээр тусаллаа. Үүнийг хөрөнгөд тусгаж авав.</p> <p>Хэлтэст шаардлагатай байсан дараах хөрөнгүүдийг ҮСХ-ноос ирүүлсэн зардлаар авлаа. Үүнд: Сандал 12 ш, цонхны хөшиг 1ш, ус буцалгагч 1ш, өрөөний дүүжин сэнс 2ш</p>		
1.3.5	<p>Байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх талаар:</p> <p>Зорилт -1: Хэлтсийн мэргэжилтнүүдэд шилжилт хөдөлгөөн орж байгаатай</p>	<p>1. 2016 онд ӨНЭЗС нь дэлгэрэнгүй байдлаар явагдаж байгаатай холбогдуулж хэлтэст 1 судлаачаар ня-бо мэргэжилтэн мэргэжлээрээ 6 жил ажилласан туршлагатай боловсон хүчин Б.Азжаргалыг авч ажиллууллаа.</p> <p>2016 оны 5 дугаар сарын 26 нд Сумдын Улсын бүртгэгч нарыг чадавхижуулах сургалтыг зохион байгуулж хэлтсийн дарга Д.Болдбаатар, мэргэжилтэн Ц.Батхишиг мэргэжилтэн А.Наранчимэг нар лекц уншиж мэргэжилтнүүд өөрсдийн ажлын чиглэлээр мэдээлэл хийлээ. Сургалтанд</p>		

	<p>холбогдуулан ҮСХ – той хамтран чадварлаг мэргэжилтэн олж ажиллуулах</p> <p>Зорилт -2: Орон нутгийн болон ҮСХ-ны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу ажилтнуудыг гадаад, дотоод, сургалтанд оролцуулах</p> <p>Зорилт -3: Хэлтсийн ажлын байранд сургалтыг зохион байгуулах</p>	<p>18 сумын 23 улсын бүртгэгч ,статистикийн ажилтан 6 нийт 29 хүн хамрагдав</p> <p>2. Хэлтсийн дарга Т.Өлзийсүрэн БНСолонгос улсын ҮСХ-ны урилгаар Монгол улсын ҮСХ-ны тамгын газрын дарга Ч.Цэвэгдоржоор ахлуулсан 18 хүний бүрэлдэхүүнтэй багт орж танилцах айлчлалд оролцлоо.</p> <p>2016 оны удирдах ажилтны зөвлөгөөнд хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нар оролцов.</p> <p>Монгол улсад Статистикийн байгууллага үүсч хөгжсөний 92 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан Хэнтий аймгийн ерөнхий боловсролын ахлах ангийн сурагчдад зориулсан “ Статистикийн боловсрол” сэдэвт хичээлийг зохион явууллаа. Сургалтанд Хэнтий аймгийн Хэрлэн сумын 1-р дунд сургуулийн төгсөх ангийн сурагчдын төлөөлөл 15 сурагч, 2-р дунд сургуулийн төгсөх ангийн сурагчдын төлөөлөл 15 сурагч, 3-р дунд сургуулийн 15 сурагч, 4-р дунд сургуулийн 15 сурагчид 4 багш нарын хамт нийт 64 хүн, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн төгсөх ангийн 4 бүлгийн 48 суралцагчид тус тус хамрагдлаа.</p> <p>3. 2016 оны 6 дугаар сараас эхлэн хэлтсийн дарга санаачлан бүх ажилтнууд өөрсдийн хариуцсан салбарын талаар бусдадаа 30 минутын лекц уншиж, танилцуулга хийж мэргэжилтэн бүхэн идэвхтэй оролцлоо.</p>		
1.4	Мэдлэг чадвараа дээшлүүлэх талаар дор дурьдсан зорилтыг хэрэгжүүлнэ.			
Мэдлэг чадвараа дээшлүүлэх зорилт	<p>1. ҮСХ-ноос болон орон нутагт зохион байгуулагдаж байгаа сургалтанд хэлтсийн дарга, мэргэжилтэн, судлаачид хамрагдаж бүтэн жилийн турш сурсан бүх л Онлайн программ, Таблет, I PAD зэргийг бүрэн эзэмшиж ашиглаж мэдлэг чадвараа дээшлүүлэн ажиллаж байна.</p>			

<p>1. Ерөнхий газраас төлөвлөсөн сургалт, семинарт бүрэн хамрагдаж, шинэ мэдээлэл олж авах</p> <p>2. Аймаг орон нутагт зохион байгуулагдах хурал зөвлөгөөнд оролцож мэдээлэл солилцоно.</p>	<ul style="list-style-type: none"> - 2016 оны удирдах ажилтны зөвлөгөөнд хэлтсийн дарга, ахлах мэргэжилтэн нар оролцов. - ҮСХ-нд явагдсан ААНБ-ын тооллын сургалтанд ахлах мэргэжилтэн Наранчимэг хамрагдаж тооллогыг амжилттай явуулав. - Бичил уурхайн судалгааны сургалтанд мэргэжилтэн Ц.Батхишиг хамрагдаж судалгааг аймаг орон нутагтаа явуулав. - ҮСХ-ноос явагддаг онлайн сургалтанд мэргэжилтэн, судлаач нар бүгд идэвхитэй хамрагдаж ирлээ. - Аймаг орон нутагт зохион байгуулагддаг сургалт, хурал зөвлөгөөнд мэргэжилтэн, судлаач нар тухай бүрд нь хамрагдав. 		
<p>3. Хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх, шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт орж буй хууль тонтгоомжийг цаг алдалгүй судлах.</p>	<ul style="list-style-type: none"> - Шинээр батлагдан гарсан хууль, тогтоомж, дүрэм журмуудыг туай бүр нь хэлтсийн мэргэжилтэн, судлаач нар уншиж судалж байна. Мөн Аймгийн цагдаагийн газраас гэмт хэрэг болон хууль эрх зүйн талаар сургалт сурталчилгааг ирж хийж мэргэжил аргай зүйн төвлөгөөг өгч байна. 		
<p>4. Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандартыг чанд мөрдөж ажиллана.</p>	<p>Төрийн албаны тухай хууль тогтоомж, стандарт, ес зүйн хэм хэмжээг чандлан сахиж ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж, байгууллагынхаа ил тод байдлыг ханган ажиллаж байна.</p>		

ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ БИЧСЭН:

ХЭНТИЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Т.ӨЛЗИЙСҮРЭН